



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/583

Алтай хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээнд тавигдах шаардлагыг хангаж, спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахаар материалаа ирүүлсэн аж ахуйн нэгжийг нэгдүгээр, тусгай зөвшөөрөл шинээр авахаар материалаа ирүүлсэн аж ахуйн нэгжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хууль тогтоомж, шаардлага журмыг зөрчсөн тохиолдолд зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авч ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар), Цагдаагийн газар (Н.Мэндбаяр), холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР


Аймгийн Засаг даргын 2011 оны  
09 дугаар сарын 15-ны өдрийн 1509 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

СПИРТИЙН ӨНДӨР БОЛОН СУЛ АГУУЛАМЖТАЙ СОГТУУРУУЛАХ  
УНДАА ХУДАЛДАХ, ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ  
СУНГАСАН АЖ АХУЙН НЭГЖҮҮД

Д/д	Сумын харьяалал	Аж ахуйн нэгжийн нэр	Дэлгүүр, үйлчилгээний газрын нэр	Байрлал	Худалдаа үйлчилгээний хэлбэр
1.	Цогт сум	Өрнөн дэлгэр өсөн арвижих ХХК	Арвижих хүнсний дэлгүүр	Сумын төв	Худалдах
2.	Есөнбулаг сум	Бишрэлт-Алтай ХХК	Номин хүнсний дэлгүүр	Оргил баг	Худалдах
3.	Есөнбулаг сум	Хөвийн өвөр аргалант ХХК	Жаргалант хүнсний дэлгүүр	Баяншанд баг	Худалдах
4.	Есөнбулаг сум	Алтайн дэл ХХК	Дааган дэл хүнсний дэлгүүр	Баянхайрхан баг	Худалдах
5.	Есөнбулаг сум	Цагирагт могой ХХК	Буян баян хүнсний дэлгүүр	Индэрт баг	Худалдах
6.	Эрдэнэ сум	Хараат өгөөмөр ХХК	Өгөөмөр хүнсний дэлгүүр	Сумын төв	Худалдах

---oOo---

Аймгийн Засаг даргын 2011 оны  
09 дугаар сарын 15-ны өдрийн 152 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт



СПИРТИЙН ӨНДӨР БОЛОН СУЛ АГУУЛАМЖТАЙ СОГТУУРУУЛАХ  
УНДАА ХУДАЛДАХ, ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ  
ШИНЭЭР ОЛГОСОН АЖ АХУЙН НЭГЖҮҮД

Д/д	Сумын харьяалал	Аж ахуйн нэгжийн нэр	Дэлгүүр, үйлчилгээний газрын нэр	Байрлал	Худалдаа үйлчилгээний хэлбэр
1.	Есөнбулаг сум	Тэмүүлэх Өндөр Оргил ХХК	Таван од хүнсний дэлгүүр	Индэрт баг	Худалдах
2.	Есөнбулаг сум	Сайхан салаа ХХК	Очир хүнсний дэлгүүр	Оргил баг	Худалдах
3.	Чандмань сум	Дээдлэн бадрангуй ХХК	Баян-Алтай хүнсний дэлгүүр	Сумын төв	Худалдах
4.	Чандмань сум	Баялаг шим ХХК	Бөхтөр маркет-2	Сумын төв	Худалдах

---oOo---